


ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
ГАА-2025/014/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хорлоол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БУГАТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА О.НЭРГҮЙ ТАНАА

2025. 02.21 № 17
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн төв 2024 онд давхардсан тоогоор 6212 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны хязгаар”-ыг 28 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр 24 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт өмнөх оноос 241,071.3 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо өссөн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

8225020050

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 406,045.6 мянган төгрөгийг нэхэмжилснээс 392,581.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч 13,464.1 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж орлого төвлөрүүлэх боломж алдсан байна.

Бусад асуудал

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 3 зорилт 42 арга хэмжээний хэрэгжилт 91.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	143,525.0	329,880.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	699,101.2	657,076.2
	Нийт хөрөнгийн дүн	842,626.2	986,956.2
	Нийт өр төлбөрийн дүн	393.0	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	842,233.2	986,956.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	842,626.2	986,956.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	756,459.8	1,248,853.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	849,978.8	1,104,130.5
	Үйл ажиллагааны үр дүн	(93,519.0)	144,722.9
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(93,519.0)	144,722.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	935,752.2	842,233.2
	Тайлант оны үр дүн	(93,519.0)	144,723.0
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
	Эцсийн үлдэгдэл	842,233.2	986,956.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	681,521.8	946,856.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	704,292.9	971,993.0
	Үйл ажиллагааны ЦМГ	(22,771.1)	(25,136.3)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(10,698.0)	(17,344.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(33,469.1)	(42,480.3)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	99,532.6	66,063.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	66,063.5	23,583.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,049,286.1	987,777.8
	Урсгал зардал	1,049,286.1	987,777.8
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,049,286.1	945,297.5
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	926,459.0	890,093.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,763.6	55,204.4
	Туслах үйл ажиллагааны орлого		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	66,063.5	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 426.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Бүртгэл тайлантай холбоотой:** Цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татвар 426.5 мянган төгрөг илүү төлөөд авлагаар тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах, 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;-ыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,464.1 мянган төгрөгийн материаллаг бус зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,464.1 мянган төгрөгийн 1 зөрчил² илэрч, зөвлөмж өгсөн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 13,464.1 мянган төгрөг хасагдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

				(мянган төгрөгөөр)	
	Нийт алдаа			Үүнээс	Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймгийн Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын нэр			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бугат сумын ЭМТ	1	426.5	1	426.5			1	426.5				
Дүн	1	426.5	1	426.5			1	426.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бугат сумын ЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			